

В. Хууль зүйн орчин ба төрийн механизм

11. Аливаа улсын Үндсэн хуулийн зорилго нь төрийн эрх мэдлийг хязгаарлахын хирээр иргэдийн эрх, эрх чөлөөгөө гарцаагүй эдлэх боломжийг бататган бэхжүүлэхэд оршдог. Энэ жишгийн дагуу Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар хүний үндсэн эрхүүдийг ангилан төрөлжүүлж, тэдгээр эрхүүдийн хөндөгдөшгүй байх баталгааг хангах үүргийг төрд оногдуулсан. Өөрөөр хэлбэл төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэсэн үг.

12. Хүний эрхүүдийг дан ганц Үндсэн хуулиар бус төрөл бүрийн салбар буюу тусгайлсан хуулиудаар давхар зохицуулдаг. Гэхдээ тэдгээр тусгай хуулиуд нь Үндсэн хуулиар тогтоосон хүний үндсэн эрхэнд ямар нэгэн байдлаар харшлах ёсгүй бөгөөд хэрэв чингэсэн тохиолдолд Үндсэн хуулийн шүүх (Цэц)-ээр уг зөрчлийг арилгана. Мөн эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй иргэн энэ тухай гомдлоо ХЭҮК-т хандан гаргах боломжтой.

13. Монгол Улс хүний эрхийн олон улсын үндсэн гол гол баримт бичгүүдэд нэгдэн орсон. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, түүний Нэмэлт I Протокол, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенц, Хүүхдийн эрхийн тухай Конвенц, түүний Нэмэлт Протокол, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенц ба түүний Нэмэлт Протокол, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын шугамаар батлагдсан Конвенциуд гэх мэт. Хамгийн сүүлд Монгол Улс НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт Протоколыг 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр соёрхон баталлаа.

14. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг. Иймд дотоодын аливаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу эсхүл шинээр хууль батлах зэрэг тохиолдолд дээрх олон улсын гэрээнд харшлахгүй байхаар зохицуулалт хийгддэг.